



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БХА-2026/14-03/ШТА-НА

ТӨРИЙН САНГИЙН ЦАХИМ ШИНЭЧЛЭЛИЙГ ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН БОДЛОГО, ОРОН НУТГИЙН ТӨРИЙН САНД ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУДАЙ УЯЛДУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу
Цахим хуудас: www.open.audit.mn

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: Munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 цахим хуудас: Altantuyam@audit.gov.mn

Аудитор Н.Батчимэг

Утас: 91113253 цахим хуудас: Batchimegn@audit.gov.mn

Аудитор Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 цахим хуудас: Bunchinsurenn@audit.gov.mn

Аудитор Г.Энхзул

Утас: 99333147 цахим хуудас: Enkhzulg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.open.audit.mn

Баянхонгор хот 2026 он

Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Аудитын менежер М.Алтантуяа

Тайланг бэлтгэсэн:

Аудитор Н.Батчимэг
Н.Бүнчинсүрэн
Г.Энхзүл

2026 оны 5 дугаар сарын 29-ний өдөр

Уг тайланг YAГ-ын цахим хуудаснаас үзнэ үү:
www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Нутгийн удирдлагын ордон,
Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум 64090,
Баянхонгор аймаг
Монгол Улс

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	4
БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БҮРДСЭН БАЙНА УУ?	5
Төрийн сангийн цахим шилжилт хөгжиж байгаа хэдий ч өмнө нь хэрэглэж буй журмуудыг сайжруулах шаардлага үүсээд байна.....	5
1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актууд холбогдох хууль тогтоомжтой нийцэж байна уу?	5
Төрийн сангийн төлбөр тооцооны систем цахимд шилжсэнтэй холбогдуулан холбогдох журмуудад өөрчлөлт оруулаагүй байна.	5
1.2. Төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдсэн байна уу?	7
Төрийн сангийн хуулийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх бүтцийг шинэчлэх шаардлагатай байна.	7
БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖИЖ БАЙНА УУ?	13
Төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж буй хэдий ч зөрчил буурахгүй байгаад цахим шинэчлэлийг төсвийн хэмнэлтийн бодлого болон орон нутгийн нөхцөл байдалтай уялдуулж, хяналтын тогтолцоог цогцоор нь сайжруулах шаардлагатай байна.....	13
2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт батлагдсан төсөв, төсвийн хуваарь, хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байна уу? .	13
Төсвийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалтын эрхийг батлагдсан хуваарийн дагуу хугацаанд нь олгоогүйгээс өр төлбөр нэмэгдэж, төсөл, арга хэмжээ дутуу болон он дамжин хэрэгжих эрсдэл үүссэн байна.	13
2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу баталгаажин, нэгдсэн хяналттайгаар хэрэгжиж байна уу?	17
Төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагаанд хяналтыг хуулийн хүрээнд хэрэгжүүлж буй хэдий ч дансны үлдэгдэл баталгаажуулаагүй, санхүүжилтийн эрх олгох журам зөрчсөн, баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн зэрэг зөрчлүүд гарч байна.....	17
2.3. Төрийн сангийн үйл ажиллагаа, хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?	22
Төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч жил бүрийн илэрч буй зөрчлийн тоо буурахгүй байгаа нь хяналтын үр нөлөөг сулруулж байна.....	22
ДҮГНЭЛТ:	27
ЗӨВЛӨМЖ:	27
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:	28

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БОНХОБТХ	Бүс орон нутаг хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
БТСГ	Биеийн тамир спортын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГҮТББ	Гэрээт үйлчилгээний төрийн бус байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МТИС	Мэдээлэл технологийн их сургууль
НАГ	Нийцлийн аудитын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТСУЦС	Төрийн сангийн удирдлагын цахим систем
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХҮГ	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар
ЦТХХК	Цахилгаан түгээх хариуцлагатай хувьцаат компани
ҮАГ	Үндэсний аудитын газар

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй өөр чиг үүрэг хэрэгжүүлж буй албан тушаалтан	9
Хүснэгт 2	Төрийн сангийн гүйлгээний нэгтгэл дүн	9
Хүснэгт 3	Төрийн сангийн гүйлгээний нэгтгэл дүн	10
Хүснэгт 4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	13
Хүснэгт 5	Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	13
Хүснэгт 6	2024-2025 Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт	14
Хүснэгт 7	Зарцуулалтын эрх олгосон байдал	14
Хүснэгт 8	Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулалтын эрх олгосон байдал	15
Хүснэгт 9	Баянхонгор аймгийн Төрийн сангийн данс	17
Хүснэгт 10	Дансны үлдэгдлийн баталгаа	18
Хүснэгт 11	Нэмэлт төсвийн зарцуулалтын гүйлгээний нэгтгэл	19
Хүснэгт 12	Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчлийн нэгтгэл	20
Хүснэгт 13	Нэр данс зөрүүтэй орлогын нэгтгэл	21
Хүснэгт 14	Дотоод хяналтын төлөвлөгөө, гүйцэтгэл	23
Хүснэгт 15	Буцаасан гүйлгээний нэгтгэл	25
Хүснэгт 16	Санхүү, төрийн сангийн хэлтэст өгсөн зөрчлийн нэгтгэл	26

Дүрслэлийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Таны ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг уу?	8
Дүрслэл 2	Цахим системийн ашиглалтын талаарх судалгааны дүн	11
Дүрслэл 3	Цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ?	11
Дүрслэл 4	Төрийн сангийн ажлыг гүйцэтгэхэд цахим системээс гадна цаасан суурьтай баримт үйлддэг үү?	12
Дүрслэл 5	Төрийн сангийн цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ?	12
Дүрслэл 6	Системүүд хоорондоо мэдээллээ үнэн зөв, шууд солилцож, уялдаа холбоотой ажиллаж чадаж байна уу?	12

<p>Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх</p>	<p>АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/01 дүгээр тушаал, газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн хийв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэлд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ-ын НАГ болон аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх. • Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитад Монгол Улсад төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, хууль тогтоомжийн нийцэл, Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч, санхүү, албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнүүд болон бусад холбогдох төрийн байгууллагуудын 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бүтцийн зохион байгуулалт, чиг үүрэг оновчтой эсэх, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр нөлөөний үнэлгээнд үндэслэн нийцлийн аудитыг хийв.</p> <p>Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д “төрийн сангийн үйл ажиллагаа гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг” гэж тодорхойлж, мөн хуулийн Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх, 35 дугаар зүйлд Төрийн сангийн нэгдсэн данс, 36 дугаар зүйлд Төрийн сангийн тогтолцоо, 37 дугаар зүйлд Төрийн сангийн нийтлэг чиг үүргүүдийг хуульчилсан байна.</p> <p>Баянхонгор аймаг, сумдын төрийн сан улсын төсвийн 266, орон нутгийн төсвийн 942, нийт 1208 дансаар 2023 онд 225,219.6 сая төгрөгийн 88,740 гүйлгээ, 2024 онд 346,700.4 сая төгрөгийн 98,742 гүйлгээ, 2025 онд 379,355.6 сая төгрөгийн 88,277 гүйлгээг банк хооронд илгээсэн байна.</p> <p>Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл 70,138.7 сая, зарлагын гүйцэтгэл 69,931.0 сая, 2024 оны орлогын гүйцэтгэл 96,641.1 сая, зарлагын гүйцэтгэл 91,829.2 сая, 2025 оны орлогын гүйцэтгэл 105,877.2 сая, зарлагын гүйцэтгэл 99,591.8 сая төгрөг байна.</p>
<p>Аудитын хязгаарлалт Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитад аймаг, сумдын анхан шатны гүйлгээг түүвэрлэн хамруулсан болно.</p> <p>Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим,</p>

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа хэрэгжүүлж, аудитор Н.Батчимэг, Н.Бүнчинсүрэн, Г.Энхзул нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлж, аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 08-аас 05 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс эхлүүлж, тайланг 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр газрын дарга, тэргүүлэх аудитораар баталгаажуулан УАГ-ын НАГ болон аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох бусад байгууллагуудад хүргүүлэв.

Хүндрэл
бэрхшээл

Байхгүй

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д “төрийн сангийн үйл ажиллагаа гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг” гэж тодорхойлж, мөн хуулийн Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх, 35 дугаар зүйлд Төрийн сангийн нэгдсэн данс, 36 дугаар зүйлд Төрийн сангийн тогтолцоо, 37 дугаар зүйлд Төрийн сангийн нийтлэг чиг үүргүүдийг хуульчилсан байна.

Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор сумдад санхүүгийн алба байгуулах шийдвэр гарч 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Баянхонгор сумын Санхүүгийн албыг 3 орон тоо, сумдын ЗДТГ-ын санхүүгийн албыг 4 орон тоо албаны дарга, төсвийн мэргэжилтэн, 2 нягтлан бодогчтой байгуулсан байна.

Засгийн газрын 2021 оны “аймгийн ЗДТГ-ын бүтцийг батлах тухай” 377 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын бүтцийг шинэчлэн баталсны дагуу аймгийн ЗДТГ-ын СТСХ хэлтсийн орон тоог 8 байхаар баталсан байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд аймгийн ЗДТГ-т Санхүү, төрийн сангийн хэлтэс, 20 сумд санхүүгийн алба, нийт 21 төрийн санд 49 албан хаагч ажиллахаас 42 албан хаагч ажиллаж үйл ажиллагаагаа явуулж байна.

Баянхонгор аймаг, сумдын төрийн сан улсын төсвийн 266, орон нутгийн төсвийн 942, нийт 1208 дансаар 2023 онд 225,219.6 сая төгрөгийн 88,740 гүйлгээ, 2024 онд 346,700.4 сая төгрөгийн 98,742 гүйлгээ, 2025 онд 379,355.6 сая төгрөгийн 88,277 гүйлгээг банк хооронд илгээсэн байна.

Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл 70,138.7 сая, зарлагын гүйцэтгэл 69,931.0 сая, 2024 оны орлогын гүйцэтгэл 96,641.1 сая, зарлагын гүйцэтгэл 91,829.2 сая, 2025 оны орлогын гүйцэтгэл 105,877.2 сая, зарлагын гүйцэтгэл 99,591.8 сая төгрөг байна.

Төрийн сангийн удирдлага мэдээллийн цахим системийн бүтэц, чиг үүрэг, системийн судалгаанд 42 албан хаагч, системийн хэрэглэгчдийн судалгаанд 130 хүн хамрагдсан байна.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БҮРДСЭН БАЙНА УУ?

ТӨРИЙН САНГИЙН ЦАХИМ ШИЛЖИЛТ ХӨГЖИЖ БАЙГАА ХЭДИЙ Ч ӨМНӨ НЬ ХЭРЭГЛЭЖ БУЙ ЖУРМУУДЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГА ҮҮСЭЭД БАЙНА

1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актууд холбогдох хууль тогтоомжтой нийцэж байна уу?

Төрийн сангийн төлбөр тооцооны систем цахимд шилжсэнтэй холбогдуулан холбогдох журмуудад өөрчлөлт оруулаагүй байна.

1.1.1. Төрийн Холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэрүүд хууль тогтоомжтой нийцэж байна уу?

Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актуудыг шинэчлэх шаардлагатай байна.

Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх, 35 дугаар зүйлд Төрийн сангийн нэгдсэн данс, 36 дугаар зүйлд Төрийн сангийн тогтолцоо, 37 дугаар зүйлд Төрийн сангийн нийтлэг чиг үүргийг тусгаж, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолын хавсралтаар “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан байна.

“Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дахь хэсгийн 3.6.4-т “Төсвийн байгууллага төрийн сангаас тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баталж өгсөн хязгаарын хүрээнд жижиг мөнгөн сан (цаашид “ЖМС” гэх)-тай байж болно” гэж заасан ба журмын 3.6.5-3.6.9 дэх заалтад жижиг мөнгөн сангийн эрх нээх, зориулалтын картын данстай болох талаар тусгасан, мөн Маягт-ТТ-6-д “Жижиг мөнгөн сангийн тайлан” гаргах маягтыг баталсан ба энэ нь төсөвт байгууллагуудад хэрэгжихгүйгээс дараах зөрчил илэрсэн байна.

Тухайбал: Аймгийн БТСГ-ын хувьд биеийн тамирын уралдаан тэмцээнд явахад дасгалжуулагч, тамирчид замын хоол, хүнс, буудлын хөлс, унааны зардлыг өөрсдөө гаргах боломжгүй, дасгалжуулагчдын хувийн дансанд шилжүүлдэг тул 2025 онд 19.9 сая төгрөгийн урьдчилгаа олгосон бөгөөд Сангийн яамны шалгалтаар санхүү төрийн сангийн хэлтэст чиглэл өгч 2026 оны 01 дүгээр сараас дараа тооцоогоор баримтын бүрдэл хангаж гүйлгээ хийлгэхийг хориглосон нь бодит байдалтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу жижиг мөнгөн сангийн эрх нээж журмын хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүлэх саналыг УАГ-ын НАГ-т уламжлав.

Төрийн сангийн төлбөр тооцооны систем цахимд шилжсэнтэй холбогдуулан дараах журмуудад өөрчлөлт оруулаагүй байна. Үүнд:

- Монгол Улсын Сангийн сайдын 2012.12.18-ны өдрийн “Журам батлах тухай” 294 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн ерөнхий нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын 2.1.5 дахь хэсэгт “Шууд захирагч нарын ахлах нягтлан бодогч нь нягтлан бодогчоор 2-оос доошгүй жил ажилласан бие даан санхүүгийн тайлан гаргах чадвартай байх” гэж заасан нь сумдад шинэ төгссөн нягтлан бодогчийг ажилд аваад хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж байна. Тухайбал: Хөдөө орон нутагт ажиллах боловсон хүчин дутагдалтай, ажиллах хүчний хомсдолтойгоос шинэ төгссөн албан хаагчдыг 3 сараар томилдог ба 2 жилийн

хугацаа болтол зөрчилтэй томилгоотой 4 нягтлан бодогч жинхлэн томилогдоогүй, 1 нягтлан бодогчийг зөвшилцлийн бичиггүй томилсон байна.

- Монгол Улсын Сангийн сайдын 2015.12.26-ны өдрийн “Заавар батлах тухай” 431 дугаар тушаалын хавралтаар баталсан “Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг, заавар”
- Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”,
- Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-
- Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”
- “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-д төрийн сангийн цахим систем, мэдээллийн аюулгүй байдал, цахим халдлагаас хэрхэн сэргийлэх талаар тусгагдаагүй, тусгайлан баталсан журамгүй,
- Төрөөс баримталж буй төсвийн хэмнэлтийн бодлого, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулиар хориглосон зарлагын гүйлгээг хянах нөхцөл ТСУЦС-д бүрдээгүй байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/683 дугаар захирамжаар “Төрийн санд төлбөр тооцоо хийх журам”-ыг баталж тус журмыг аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/526 дугаар захирамжаар “Төрийн санд төлбөр тооцооны эрх нээх журам” болгон шинэчлэн баталсан байна. Энэхүү журмын зорилго нь байгууллагуудын нягтлан бодогчийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрхийн актуудыг хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэл, мэдээ тайланг, хугацаанд нь үнэн зөв хөтөлж гаргах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, нягтлан бодогчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн байна.

Тус журамд Санхүү албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, байгууллагын дарга, эрхлэгчийн эрх үүрэг, нягтлан бодогч, няравын үүргийг мөн тусгасан нь санхүүгийн сахилба бат сайжрах нөхцөл боломжийг нэмэгдүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/682 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтаар “Сумын санхүүгийн албаны ажлын үр дүнг үнэлж, урамшуулах тухай” журам, хоёрдугаар хавсралтаар “Нягтлан бодогчдын ажлын үр дүнг үнэлж, дүгнэх тухай” журмыг тус тус баталсан байна.

“Сумын санхүүгийн албаны ажлын үр дүнг үнэлж, урамшуулах тухай” журмыг цахим системд шилжсэнтэй холбоотойгоор сүүлийн 3 жил үнэлээгүй байна.

“Нягтлан бодогчдын ажлын үр дүнг үнэлж, дүгнэх тухай” журмын дагуу аймгийн төсвийн нягтлан бодогчдын ажлыг хагас, бүтэн жилээр үнэлж, ур чадварын нэмэгдлийг 10-25 хувиар тооцон олгох саналыг төсөв захирагч нарт аймгийн ЗДТГ-ын СТЦХ-ийн албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна. Тус үнэлгээнд аймгийн Татварын газар, Нийгмийн даатгалын газар, Санхүүгийн хяналт дотоод аудитын газраас хөндлөнгийн мэдээллийг харгалзан үзсэн байна.

1.2. Төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдсэн байна уу?

Төрийн сангийн хуулийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх бүтцийг шинэчлэх шаардлагатай байна.

1.2.1. Төрийн сангийн үйл ажиллагааг явуулж буй бүтэц зохион байгуулалт оновчтой байна уу?

Сумдад мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байдлаас шалтгаалж төрийн сангийн үйл ажиллагаанд тавих хяналт сулрах эрсдэлтэй байна.

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2¹ дахь заалтаар аймаг, нийслэлийн төрийн сан нь тухайн шатны ЗДТГ-ын дэргэд байхаар хуулчилж өгсөний дагуу Засгийн газрын 2002 оны 101 дүгээр тогтоолоор аймгийн ЗДТГ-ын бүтцэд төрийн сангийн хэлтсийг бий болгон аймгийн Төрийн санд ерөнхий нягтлан бодогч болон тухайн төсөвтэй харилцагч 20 хүртэл төсөвт байгууллага тутамд нэг нягтлан бодогч (төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн) байхаар тогтоосон байна. Засгийн газрын 2021 оны “аймгийн ЗДТГ-ын бүтцийг батлах тухай” 377 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын бүтцийг шинэчлэн баталсны дагуу аймгийн ЗДТГ-ын СТСХ хэлтэс 8 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3²-т сумдад санхүүгийн нэгдсэн алба байгуулж болно гэж заасны дагуу Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор сумдад санхүүгийн алба байгуулах шийдвэр гарч 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Баянхонгор сумын Санхүүгийн албыг 3 орон тоо, сумдын ЗДТГ-ын санхүүгийн албыг 4 орон тоо албаны дарга, төсвийн мэргэжилтэн, 2 нягтлан бодогчтой байгуулсан.

Баянхонгор аймгийн хэмжээнд 2023-2025 онд 145 нягтлан бодогч ажиллахаас 2023 онд 129, 2024, 2025 онд 134 нягтлан бодогч ажилласан ба жилд дунджаар 11-16 нягтлан бодогчийн орон тоо дутуу ажилласан байна. Баянхонгор аймаг, сумдын төрийн сангийн чиг үүрэг хэрэгжүүлж байгаа албан хаагчдын 35.7 хувь нь 3 хүртэлх жил, 64.3 хувь нь 3-с дээш жил ажиллаж байна.

Сумдын төрийн сангийн мэргэжилтнүүд санхүү албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа нь хяналтын тогтолцоог алдагдуулах эрсдэлтэй байна. Тухайлбал:

- *Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагч, бүтэц, чиг үүргийн судалгаагаар батлагдсан бүтэц, орон тоогоор 49 албан хаагч ажиллахаар байхад 2026 оны 05 сарын 25-ны өдрийн байдлаар 42 албан хаагч ажиллаж, мэргэжлийн боловсон хүчин дутмаг байдлаас шалтгаалж Бууцагаан, Богд, Хүрээмарал сумд санхүүгийн албаны даргагүй, Баянговь, Баацагаан, Галуут, Гурванбулаг сумд нь Төрийн сангийн мэргэжилтэнгүй, эдгээр ажлыг хавсран гүйцэтгэж байна.*
- *Баянхонгор аймаг, сумын төсвийн байгууллагуудад ажиллах боловсон хүчин хомсдолтой байгаагаас шалтгаалж Баянхонгор сумын 5 дугаар сургуулийн нягтлан бодогч, Баацагаан сумын ЗДТГ-ын нягтлан бодогчийн ажлыг, Баянхонгор*

¹ - Энэ хуулийн 36.3-т заасан нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх алба байгуулах асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.

² - Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгонд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно.

сумын 9 дүгээр цэцэрлэгийн нягтлан бодогч, Баян-Овоо сумын Цэцэрлэгийн нягтлан бодогчийн ажлыг тус тус хавсран гүйцэтгэж байна.

- Бууцагаан сумын ЗДТГ-ын нягтлан бодогч төсөвт 4 байгууллага, Заг сумын ЗДТГ-ын нягтлан бодогч төсөвт 5 байгууллагын нягтлан бодогчоор ажиллаж байна.
- Төсвийн 4 нягтлан бодогч туршилтын хугацаа дууссан боловч ажилласан жил хүрээгүй тул жинхлэн томилогдоогүй, 1 нягтлан бодогчийг зөвшилцлийн бичиггүй томилсон.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1-т заасан “Санхүүгийн албаны чиг үүргийн жишиг”-тэй нийцэхгүй байна.

Иймд төрийн сангийн цахим шилжсэнтэйгээр холбоотойгоор сумын санхүүгийн албаны бүтцийг шинэчлэх саналыг ҮАГ-т Нийцлийн аудитын газарт уламжлав.

1.2.2. Төрийн сангийн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүрэг давхардалгүй, ажлын байрны тодорхойлолттой нийцэж байна уу?


Төрийн сангийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт 2019 онд батлагдсан ба 2023 онд цахимд шилжсэнтэй холбоотой чиг үүргүүдийг нэмэлтээр тусгаж батлаагүй нь өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь аймгийн төсвийн төлөвлөлт бүрдүүлэлт, хуваарилалт, төрийн сангийн зарлага санхүүжилтийг гүйцэтгэх, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах, нийгмийн даатгал, хөрөнгө оруулалт зээлийн бодлого төлөвлөлт, зохицуулалт, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, засаг даргын дэргэдэх агентлагуудын төсөв санхүүгийн орлого, зарлагын үйл ажиллагаанд байнга хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба бусад газар, хэлтсийн чиг үүрэгтэй давхцаагүй байна.

Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”, Төрийн албан зөвлөлийн 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоолын дагуу 2019 онд аймгийн СТСХ, сумдын Санхүүгийн албад нь албан тушаалын тодорхойлолтыг баталгаажуулсан байна.

Аудитаар хэрэгжүүлж буй чиг үүрэг ажлын байрны тодорхойлолттой нийцэж байгаа эсэх талаар төрийн сангийн ажилтнуудаас авсан судалгаагаар 31 албан хаагч буюу 73.8 хувь нь “бүрэн нийцдэг” гэж хариулсан байна.

Дүрслэл 1. Таны ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг уу?



Эх сурвалж: Судалгаа 1. Бүтэц, чиг үүрэг

Албан тушаалын тодорхойлолт 2019 онд батлагдсанаас хойш шинэчлэгдээгүй байна. Үүнд:

- Төрийн сангийн удирдлагын цахим системд шилжсэнтэй холбоотойгоор хийгдэх ажлын чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод нэмэлтээр тусгаагүй.
- Сумын санхүү албаны даргын албан тушаалын тодорхойлолтын 2-р зорилтын 12-т "Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн баримтад 2 дугаар гарын үсэг зурж тайлан баланс гаргах" гэж тусгасан ба тусдаа сангийн нягтлан бодогчтой тул нийцэхгүй байна.
- Сумдын санхүү албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнүүд орон нутагт зарласан худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ордог ба эргээд хөрөнгө оруулалтын гүйлгээг хянаж баталж байгаад эрсдэл үүсэж байна.
- Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн ажилтны ажил үүргийн жишиг заавар"-ын 1.2.12-т Төсвийн тухай хуулийн дагуу нэмэлт төсвийн эрхийг хянан олгох ажил аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчид хянан олгохоор заасан ба ТСУЦС-д орон нутаг хариуцсан төсвийн мэргэжилтэн эрхийг нээхээр тохиргоо хийгдсэн нь журмын заалттай зөрчилдөж байна

Иймд шат шатны төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын жишиг тодорхойлолтыг бий болгох зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүлэх саналыг ҮАГ-ын НАГ-т уламжлав.

Төрийн сангийн чиг үүрэг гүйцэтгэх албан хаагчид албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй дараах чиг үүргийг хавсран хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй өөр чиг үүрэг хэрэгжүүлж буй албан тушаалтан

№	Албан тушаалын нэр	Ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй өөр чиг үүрэг
1	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	Санхүүгийн зохицуулах хорооны Баянхонгор аймгийн орон нутаг дахь төлөөлөгч, Төрийн албаны салбар зөвлөлийн дарга
2	Бүртгэлийн мэргэжилтэн	Санхүүгийн зохицуулах хорооны Баянхонгор аймгийн орон нутаг дахь төлөөлөгч
3	Орон нутаг хариуцсан төсвийн мэргэжилтэн	Орон нутгийн болон Улсын төсвийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансны зарлагын эрх нээдэг.
4	Өлзийт сумын Санхүү албаны дарга	Байгууллагын дотоод хяналтын ажилтан.
5	Өлзийт сумын Төрийн сангийн мэргэжилтэн	Өмч хамгаалал байнгын зөвлөлийн нарийн бичгээр ажилладаг.

Эх сурвалж: Судалгаа 1. Бүтэц, чиг үүрэг

Баянхонгор аймаг, сумдын төрийн сан 2023-2025 онд нийт 1,030,115.1 сая төгрөгийн 297,153 гүйлгээ хийснээс төсвийн багц хүрэлцэхгүй, үнийн дүн зөрүүтэй, данс алдаатай гэх мэт шалтгаанаар 20,626.0 сая төгрөгийн 6,913 гүйлгээ амжилтгүй, эдийн засгийн ангилал буруу, анхан шатны баримтын бүрдэл дутуу, захирамж тушаал байхгүй гэх мэт шалтгаанаар 58,213.5 сая төгрөгийн 14,481 гүйлгээг буцааж, 951,275.6 сая төгрөгийн 275,759 гүйлгээг банк хооронд илгээсэн байна.

Хүснэгт 2. Төрийн сангийн гүйлгээний нэгтгэл дүн (сая.төгрөгөөр)

Төлөв	2023 он		2024 он		2025 он	
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
Нийт гүйлгээ	96,633	243,715.6	105,524	374,410.3	94,996	411,989.2

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл

Амжилтгүй гүйлгээ	2,794	6,701.1	1,959	5,758.1	2,160	8,166.8
Буцаасан гүйлгээ	5,099	11,794.9	4,823	21,951.8	4,559	24,466.8
Банк хооронд илгээсэн	88,740	225,219.6	98,742	346,700.4	88,277	379,355.6

Эх сурвалж: Төрийн сангийн дансны хуулга

Баянхонгор аймаг, сумдын төрийн сан 2023 онд 225,219.6 сая төгрөгийн 88,740 гүйлгээ, 2024 онд 346,700.4 сая төгрөгийн 98,742 гүйлгээ, 2025 онд 379,355.6 сая төгрөгийн 88,277 гүйлгээг банк хооронд илгээсэн байна.

Хүснэгт 3. Төрийн сангийн гүйлгээний нэгтгэл дүн (сая.төгрөгөөр)

№	Төрийн сангийн нэр	2023 он		2024 он		2025 он	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Баянхонгор аймгийн Төрийн сан	24,175	110,800.1	29,917	169,222.0	23,869	174,523.0
2	Баацагаан сумын төрийн сан	2,502	3,418.0	2,801	5,249.5	2,467	5,932.0
3	Баянбулаг сумын төрийн сан	2,287	3,101.1	2,607	4,859.3	2,368	5,492.1
4	Баянговь сумын төрийн сан	2,389	3,708.4	2,591	6,187.2	2,267	6,797.2
5	Баянлиг сумын төрийн сан	2,439	4,697.6	2,477	7,318.7	2,621	8,548.1
6	Баян-Овоо сумын төрийн сан	2,095	4,517.0	2,370	6,516.5	2,189	6,150.1
7	Баян-Өндөр сумын төрийн сан	2,151	4,074.6	2,620	6,133.4	2,263	6,704.7
8	Баянхонгор сумын төрийн сан	16,041	38,987.9	16,084	62,021.2	15,884	72,916.5
9	Баянцагаан сумын төрийн сан	2,364	4,611.8	2,665	6,820.0	2,549	7,238.7
10	Богд сумын төрийн сан	2,726	4,065.6	3,114	6,235.9	2,729	6,998.0
11	Бөмбөгөр сумын төрийн сан	2,394	4,017.6	2,638	6,263.0	2,474	7,417.0
12	Бууцагаан сумын төрийн сан	3,496	5,233.4	3,505	8,153.7	3,345	8,965.3
13	Галуут сумын төрийн сан	2,775	4,564.7	3,213	6,430.6	3,029	7,457.5
14	Гурванбулаг сумын төрийн сан	2,778	3,404.4	2,834	5,493.3	2,707	6,385.0
15	Жаргалант сумын төрийн сан	2,714	3,975.4	3,062	6,364.4	2,678	6,890.4
16	Жинст сумын төрийн сан	2,547	2,850.3	2,612	4,590.1	2,332	5,213.8
17	Заг сумын төрийн сан	2,689	3,107.8	2,750	4,626.5	2,501	4,547.5
18	Өлзийт сумын төрийн сан	3,199	4,459.6	3,298	6,869.2	3,158	7,672.2
19	Хүрээмарал сумын төрийн сан	2,386	3,065.9	2,532	4,661.1	2,189	5,177.0
20	Шинэжинст сумын төрийн сан	1,842	4,627.2	2,084	6,718.2	1,968	11,496.9
21	Эрдэнэцогт сумын төрийн сан	2,751	3,931.2	2,968	5,966.6	2,690	6,832.3
Нийт дүн		88,740	225,219.6	98,742	346,700.4	88,277	379,355.6

Эх сурвалж: Төрийн сангийн дансны хуулга

Гүйлгээний тооноос харахад 2023-2025 онд сумдын төрийн сангийн мэргэжилтэн 8-10 байгууллагын 1,842-3,505 гүйлгээ хийсэн бол Баянхонгор сумын Төрийн сан 1 мэргэжилтэн 15-16 байгууллагын 7,942-8,042 гүйлгээ, аймгийн СТСХ-ийн 1 мэргэжилтэн 23-24 байгууллагын 11,935-14,959 гүйлгээ хийсэн нь ажлын ачааллын харилцан адилгүй байдлыг харуулж байна.

1.2.3. Төрийн сангийн цахим системийн удирдлага, зохицуулалт, мэдээллийн аюулгүй байдал нь холбогдох хууль тогтоомж, стандартад нийцэж, хэрэгцээ шаардлагыг нь бүрэн хангаж байна уу?


Төрийн сангийн цахим системийн мэдээллийн аюулгүй байдлын талаар холбогдох журамд тусгагдаагүй байна.

Төрийн сангийн удирдлагын цахим системд 21 албан тушаалтан батлах чиг үүрэгтэй, 23 албан тушаалтан хянах чиг үүрэгтэй оролцож байна.

ТСУЦС-д гүйлгээг хянах, батлах эрхээр нэвтэрхийн тулд төрийн сангийн мэргэжилтэн, санхүүгийн албаны дарга нар өөрсдийн эрхээр буюу нэвтрэлтийн нэгдсэн системээр нэвтэрч дамжиж ордог ба өөр төхөөрөмжөөр нэвтрэх үед цахим шуудан, гар утасны дугаараар код илгээн баталгаажуулж нэвтэрдэг.

Төрийн сангийн гүйлгээг батлах үед байгууллагын даргын бүртгэлтэй утасны дугаарт баталгаажуулах код ирдэг ба нягтлан бодогч нар даргын эрхээр баталгаажуулах кодыг авч гүйлгээг баталгаажуулах эрсдэлтэй байна.

Дүрслэл 2. Цахим системийн ашиглалтын талаарх судалгааны дүн



Эх сурвалж: Судалгаа 2. Систем


Төрийн сангийн нэгдсэн сервер аймгийн ЗДТГ-ын серверийн өрөөнд байршдаг ба серверийн өрөөнд мэдээлэл технологийн ажилтан хурууны хээгээр нэвтэрдэг, нууцын дотоод сүлжээтэй холбоотой асуудлыг тагнуулын ажилтанд мэдэгдэж шийдвэрлэдэг байна.

Төрийн сангийн удирдлагын цахим системийн шинэчлэлтэй холбоотой Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем (Finperform)-д мэдээлэл зөрүүтэй татагдах, ачаалал ихтэй үед гүйлгээ бүрэн дамждаггүй уддаг зэрэг эрсдэлтэй байдал үүсэж байна.

Төрийн сангийн нэгдсэн системээс шилэн дансны нэгдсэн цахим хуудас руу мэдээллийг үнэн зөв татах, хөрөнгө оруулалтын гүйлгээг ОНХС-ийн удирдлагын бүртгэл мэдээллийн систем, улсын төсвийн хөрөнгө оруулалтын программуудын хооронд мэдээллийг дамжуулах, уялдааг сайжруулах шаардлагатай байна.

Тухайлбал: Шилэн дансны цахим систем, ОНХС-ийн удирдлага мэдээллийн системийн хөгжүүлэлт зогссон нь харилцан мэдээлэл солилцох боломжгүй байна.

Цахим систем ашиглахад 67.4 хувь нь интернэтийн саатал, 18.7 хувь нь цахилгаан, 2.3 хувь нь тоног төхөөрөмжийн хүндрэл бэрхшээл гардаг, 11.6 хувь нь хүндрэл бэрхшээл байхгүй гэж хариулсан байна.




Дүрслэл 3. Цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ?

Эх сурвалж: Судалгаа 2. Систем

Судалгаагаар цахим системээс гадна цаасан архивын нэгж үүсгэдэг байгууллага 9.3 хувийг эзэлж байна. Үүнд СТСХ болон Баянговь, Баянлиг сумдын нууцын байгууллагын баримтыг архивын нэгж болгон аймгийн Төрийн архивын хэлтсийн даргад шилжүүлж, нууцын архивд хадгалуулдаг байна.

Дүрслэл 4. Төрийн сангийн ажлыг гүйцэтгэхэд цахим системээс гадна цаасан суурьтай баримт үйлддэг үү?




Эх сурвалж: Судалгаа 2. Систем

Цахим судалгааны үр дүн:

Төрийн сангийн удирдлагын цахим систем хэрэглэгчдээс авсан цахим судалгаанд 130 хэрэглэгч хамрагдсан ба судалгааны үр дүнг харуулбал:

Төрийн сангийн удирдлагын цахим систем ажлын хэрэгцээг 42.3 хувь буюу 55 хэрэглэгч “бүрэн хангаж байна”, 56.9 хувь буюу 74 хэрэглэгч “хэвийн”, 0.8 хувь буюу 1 хэрэглэгч “хангалтгүй” гэж хариулсан байна.


Дүрслэл 5. Төрийн сангийн цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ?



Эх сурвалж: Цахим судалгаа

Судалгаанд 130 хүн хамрагдсанаас системүүд хоорондоо мэдээллээ үнэн зөв, шууд солилцож, уялдаа холбоотой ажиллаж чадаж байгаа эсэхэд 71.5 хувь буюу 93 хэрэглэгч “Тийм”, 28.5 хувь буюу 37 хэрэглэгч “Үгүй” гэж хариулсан байна.

Дүрслэл 6. Системүүд хоорондоо мэдээллээ үнэн зөв, шууд солилцож, уялдаа холбоотой ажиллаж чадаж байна уу?



Эх сурвалж: Цахим судалгаа

БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖИЖ БАЙНА УУ?

ТӨРИЙН САНГИЙН ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХЭДИЙ Ч ЗӨРЧИЛ БУУРАХГҮЙ БАЙГААД ЦАХИМ ШИНЭЧЛЭЛИЙГ ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН БОДЛОГО БОЛОН ОРОН НУТГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛЖ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ ЦОГЦООР НЬ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт батлагдсан төсөө, төсвийн хуваарь, хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байна уу?

Төсвийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалтын эрхийг батлагдсан хуваарийн дагуу хугацаанд нь олгоогүйгээс өр төлбөр нэмэгдэж, төсөл, арга хэмжээ дутуу болон он дамжин хэрэгжих эрсдэл үүссэн байна.

2.1.1. Төрийн санхүүжилтийн эрх олголт нь батлагдсан төсвийн хуваарь, хууль тогтоомж, холбогдох баримт бичгийн шаардлагад нийцэж, хугацаанд нь олгож байна уу?

Төрийн санхүүжилтийн эрх олголт нь орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлээс шалтгаалж батлагдсан төсвийн хуваарийн дагуу хугацаандаа хийгдээгүй байна.

Баянхонгор аймгийн СТСХ нь 2023-2025 оны аймгийн ТЕЗ-ийн төсвийг аймгийн ИТХ-аар жил бүр батлуулж оны дундуур 1 удаа тодотгол хийсэн байна.

Оны эхэнд аймгийн Засаг даргын захирамжаар сар улирлын хуваарийг батлуулж төсвийн нэгтгэлийн программ болон Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд оруулж төрийн сангийн төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

Баянхонгор аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээр 2023 онд 23,195.8 сая, 2024 онд 34,182.5 сая, 2025 онд 28,978.1 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Хүснэгт №4 Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг (сая төгрөгөөр)

Огноо	Санхүүгийн дэмжлэг	Огноо	Санхүүгийн дэмжлэг	Огноо	Санхүүгийн дэмжлэг
2023-01-27	1,653.70	2024-01-24	3,201.80	2025-01-26	3,147.10
2023-02-08	1,653.70	2024-02-06	3,201.80	2025-02-10	3,147.10
2023-03-13	1,653.70	2024-03-13	3,201.80	2025-03-11	3,147.10
2023-04-10	1,653.70	2024-03-25	1,000.00	2025-04-10	3,147.10
2023-05-16	1,653.70	2024-04-22	4,201.80	2025-05-07	4,147.10
2023-06-13	1,653.70	2024-05-14	4,201.80	2025-06-12	3,147.10
2023-07-05	2,212.30	2024-06-13	3,201.80	2025-07-08	1,349.20
2023-08-10	2,212.30	2024-07-08	2,701.80	2025-08-19	1,349.20
2023-09-06	2,212.30	2024-08-11	2,701.80	2025-08-28	1,000.00
2023-10-13	2,212.30	2024-09-13	2,701.80	2025-09-15	1,349.20
2023-11-15	2,212.30	2024-10-21	2,701.80	2025-10-13	1,349.20
2023-12-13	2,212.30	2024-11-20	582.3	2025-11-24	1,200.00
	0	2024-12-10	582.3	2025-12-12	1,498.50
Нийт дүн	23,195.80		34,182.50		28,978.10

Эх сурвалж: Орон нутгийн ерөнхий орлогын дансны хуулга

Мөн Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүгийн дэмжлэгээр 2023 онд 14,235.2 сая, 2024 онд 20,790.0 сая, 2025 онд 17,926.8 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Хүснэгт №5 Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг (сая төгрөгөөр)

Он сар	Дүн	Он сар	Дүн	Он сар	Дүн
2023-02-28	773.5	2024-02-22	1,744.6	2025-02-19	781.7
2023-03-27	1,009.4	2024-03-28	1,744.6	2025-03-28	931.7
2023-04-25	265.7	2024-05-01	1,728.4	2025-04-29	847.2
2023-04-26	976.0	2024-05-29	1,995.0	2025-05-15	210.0
2023-05-26	966.6	2024-06-26	1,741.9	2025-05-28	992.9

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл

2023-06-15	966.6	2024-07-29	1,704.5	2025-06-27	1,153.6
2023-07-21	1,141.0	2024-08-30	1,701.0	2025-07-25	1,451.3
2023-07-31	396.7	2024-09-27	1,952.5	2025-08-27	1,674.2
2023-08-29	1,680.8	2024-09-30	335.7	2025-08-28	453.0
2023-09-26	1,361.4	2024-10-31	1,476.4	2025-09-24	1,830.8
2023-10-25	1,320.9	2024-11-28	1,690.6	2025-10-22	1,678.6
2023-10-31	446.8	2024-12-18	1,376.4	2025-10-24	577.6
2023-11-28	1,377.4	2024-12-19	501.5	2025-11-28	1,829.4
2023-12-20	1,355.9	2024-12-24	736.2	2025-12-25	3,514.9
2023-12-20	196.5	2024-12-24	360.8		-
Нийт дүн	14,235.2		20,790.0		17,926.8

Эх сурвалж: Орон нутгийн ерөнхий орлогын дансны хуулга

Дээрх хүснэгтээс харахад улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу сар бүр олгож байгаа боловч Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.5.1³ дахь заалтын дагуу сар бүрийн 5-ны дотор санхүүжилтийг олгоогүй байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8⁴-т заасны дагуу аймгийн засаг даргын захирамжаар оны эхэнд сар улирлын хуваарийг батлуулан төсөвт байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг олгож байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяаны байгууллагуудын орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт 2024 онд 75,521.7 сая төгрөг олгохоор баталж 74,526.6 сая, 2025 онд 87,156.7 сая төгрөг олгохоор баталж 81,023.5 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг олгосон байна.

Хүснэгт №6 2024-2025 Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгох санхүүжилт (сая төгрөгөөр)

Он	Оны эхэнд батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Олгосон санхүүжилт
2024	70,033.4	75,521.7	74,526.6
2025	87,156.7	84,818.5	81,023.5

Эх сурвалж: Төсвийн хуваарь

Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан сар улирлын хуваарийн дагуу зарцуулалтын эрхийг олгож байгаа эсэхийг дансны хуулгатай тулгаж үзэхэд улсын төсөв байгууллагуудын тогтмол зардлыг хуваарийн дагуу, сумдын ЗДТГ, ИТХ-ын санхүүжилтийг орлого төвлөрүүлэлттэй холбоотойгоор батлагдсан хуваарийн дагуу олгож чадахгүй байна.

Хүснэгт №7 Зарцуулалтын эрх олгосон байдал (сая төгрөгөөр)

он	Үзүүлэлт	нийт дүн /сая төг/	Сар											
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
2024	Оны эхэнд батлагдсан төсөв	70,033.4	6,641.0	6,525.4	6,813.1	7,118.0	5,907.6	5,163.5	4,643.7	4,446.4	5,069.3	5,963.1	5,850.7	5,891.5
	Тодотгосон төсөв	75,521.7	6,733.6	8,211.4	7,092.0	7,210.5	6,237.2	5,746.4	4,607.1	4,178.5	5,127.8	8,156.5	6,173.8	6,037.5
	Олгосон санхүүжилт	74,526.7	6,153.7	6,945.6	6,928.7	6,345.6	6,360.2	6,041.4	4,068.1	4,129.1	5,135.2	7,588.9	7,329.8	7,500.2
	Зөрүү	995.1	579.9	1,265.8	163.3	864.9	(123.0)	(295.0)	539.0	49.4	(7.4)	567.6	(1,156.0)	(1,462.8)
2025	Оны эхэнд батлагдсан төсөв	87,156.7	9,131.1	8,618.8	8,573.0	8,360.8	6,869.3	5,993.8	5,228.9	5,170.2	6,181.8	7,637.2	7,621.8	7,770.0
	Тодотгосон төсөв	84,818.5	9,170.6	8,817.2	9,007.6	9,026.3	7,097.8	6,165.4	4,833.0	4,082.0	4,732.5	9,227.8	1,381.4	11,277.0
	Олгосон санхүүжилт	81,023.5	7,968.9	8,283.9	8,017.6	8,369.9	6,440.6	6,274.5	4,699.9	4,522.8	4,672.8	7,765.3	4,296.7	9,710.6
	Зөрүү	3,795.0	1,201.8	533.3	990.0	656.4	657.2	(109.1)	133.1	(440.8)	59.7	1,462.5	(2,915.3)	1,566.3

Эх сурвалж: Төсвийн хуваарь

³ - Төв төрийн сан нь энэ журмын 2.4.1-2.4.9-д заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор, улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг эрх нээснээс хойш ажлын 2 өдрийн дотор мөн журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно;

⁴ - 37.1.8.төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

Дээрх хүснэгтээс харахад 2024 онд 1-4 сар, 7-8 сар, 10 саруудад дутуу 5,6,9,11,12 саруудад илүү, 2025 онд 1-5 сар, 7 сар, 9-10 саруудад дутуу, 6 сар, 9-10 сар, 12 саруудад илүү олгосон байна. Мөн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн орлогоос шалтгаалж сар бүр олгох санхүүгийн дамжлэгийг сарын бүрийн 10-ны өдрөөс хойш олгогдож байна.

2.1.2. Төрийн зарцуулалтын эрх олголт нь батлагдсан төсөв, зориулалт, эдийн засгийн ангилал болон шаардлагад нийцэж хэрэгжиж байна уу?

Төрийн болон хөрөнгө оруулалтын зарцуулалтын эрхийг шилжүүлгийг төсвийн хуваарийн дагуу биш оны сүүлээр ихэвчлэн шилжүүлснээс төсөл арга хэмжээ дутуу хэрэгжих, он дамжих, чанаргүй хийгдэх эрсдэл үүсэж байна.

Аймаг, сумдын ЗДТГ-ын “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага” хөтөлбөрийн 12 зориулалт арга хэмжээнд 2024 онд 33,899.3 сая төгрөгийн төсөв батлагдаж, 33,776.9 сая, 2025 онд 13 зориулалт арга хэмжээнд 38,793.5 сая төгрөг батлагдаж 36,864.0 сая төгрөгийн зарцуулалтын эрхийг олгосон байна.

Хүснэгт №8 Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулалтын эрх олгосон байдал (сая төгрөгөөр)

Хөтөлбөр	Зориулалт	2024 он			2025 он		
		Батлагдсан төсөв	Эрх нээсэн	Зөрүү	Батлагдсан төсөв	Эрх нээсэн	Зөрүү
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	21,075.7	20,886.8	188.9	22,900.9	22,123.9	777.0
	80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	209.3	209.3	0.0	277.8	264.8	13.0
	80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	4,135.2	4,076.2	59.0	4,694.1	4,502.2	191.9
	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	82.0	82.0	0.0	54.0	38.8	15.2
	80513 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	135.0	135.0	0.0	-	-	0.0
	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	524.7	534.3	(9.6)	610.0	560.9	49.1
	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	3,712.7	3,755.2	(42.5)	2,384.3	2,270.6	113.6
	81104 Бусад ангилагдаагүй нөөц хөрөнгө	-	-	0.0	2,077.3	2,004.2	73.1
	81518 Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх	-	-	0.0	1,155.8	880.4	275.4
	81549 Ахмадын сан	2.0	2.0	0.0	14.6	10.5	4.1
	81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	2,018.6	2,123.0	(104.4)	2,287.8	1,788.9	498.9
	80801 Нөхөн олговор	-	-	0.0	-	54.7	(54.7)
	81806 Дотуур байрны үйлчилгээ	-	-	0.0	-	16.0	(16.0)
	82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	7.7	139.3	(131.6)	7.7	6.4	1.3
	82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	1,746.3	1,620.4	126.0	2,238.9	2,258.1	(19.3)

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл

82310	Гамшигаас сургалт, сурталчилгаа	250.2	213.5	36.7	90.5	83.7	6.8
Нийт дүн		33,899.3	33,776.9	122.4	38,793.5	36,864.1	1929.4

Эх сурвалж: Дансны хуулга

Дээрх зарцуулалтын эрх олгосон байдлыг харвал зарим зориулалт арга хэмжээнд батлагдсан төсвөөс давуулан болон дутуу эрх олгосон, мөн батлагдсан төсөвгүй арга хэмжээнд зарцуулалтын эрх нээсэн байна. Мөн 2025 онд 1,929.4 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг дутуу нээсэн нь Сангийн яамнаас оны эцэст зарцуулах эрхийг нээж өгөөгүтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

1. Баянхонгор сумын ЗДТГ 15.4 сая, Шинэжинст сумын ЗДТГ 19.5 сая төгрөгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэн 2024 онд зарцуулах эрхийг нээсэн байна.

2. Баян-Овоо сумын ЗДТГ “81806 дотуур байрны үйлчилгээ” -нд 16.0 сая, Гурванбулаа сумын ЗДТГ “80801 нөхөн олговор”-д 54.7 сая төгрөгийг 2025 оны төсөвт зарцуулах эрхийг нээсэн ба эдгээр арга хэмжээнүүд нь батлагдаагүй зориулалт, арга хэмжээнүүд байна. Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8⁵, 41 дүгээр зүйлийн 41.43⁶ дах заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд батлагдсан зориулалт арга хэмжээний дагуу зарцуулалтын эрх олгож байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт эрх олгосон байдлыг түүвэрлэн үзэхэд батлагдсан сар улирлын хуваарийг дагаж мөрдөөгүй 2025 онд эхний хагас жилд 17.6 хувь, сүүлийн хагас жилд 82.4 хувийг санхүүжилтийг олгосон байгаа нь төсөл арга хэмжээ дутуу хэрэгжих, он дамжих хэрэгжих чанаргүй хийгдэх эрсдэл үүсэж байна.

Мөн орон нутагт улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийн эрхийг нээж өгөөгүтэй холбоотойгоор 2025 оны 12 сарын 30-д сумдад аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг шилжүүлсэн нь гүйлгээ хийх боломжгүй нөхцөл байдал үүссэнээс өр төлбөр нэмэгдэх нөхцөл байдал үүссэн байна.

Баянхонгор аймгийн Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар барьцаа хөрөнгө оруулалттай холбоотой 9.9 сая төгрөгийн 1 зөрчил, техник хяналтын данстай холбоотой 2024 онд 500.0 сая төгрөгийн 1 зөрчил, 2025 онд 21.2 сая төгрөгийн 1 зөрчил илэрч нийт 3 албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг тооцож ажилласан байна. Үүнд:

- Барьцаа данснаас аймгийн ЗДТГ-ын албаны хэрэгцээнд худалдан авсан Land Cruiser 200 жийп автомашины барьцаа 9.9 сая төгрөгийг гэрээнд заасан хугацаанаас нь өмнө аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/399 дугаар захирамжаар чөлөөлсөн.
- Техник хяналтын зардлаас аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17/57 дугаар тогтоолоор Бусад эх үүсвэрийн орлогоор 500.0 сая төгрөг баталж 2024.09.27-нд 150.0 сая, 2024.12.11-нд 350.0 сая нийт 500.0 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд шилжүүлж зарцуулсан.

⁵ - төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

⁶ - "зарцуулалтын эрх" гэж батлагдсан төсвийн хүрээнд төсвийн байгууллагын сар, улиралд зарцуулах төсвийн дээд хязгаарыг;

- *Техник хяналтын данснаас аймгийн Засаг даргын 2025 оны А/169 дүгээр захирамжаар аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн дарга, мэргэжилтнүүд, Баянхонгор Эрчим хүч ЦТХХК-ны албан хаагчдыг БНХАУ-ын Гуанжоу хотод болох Кантон фэйр олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцож туршлага судлахад 16.5 сая, БНХАУ-ын Жючуаний мужийн МТИС үйл ажиллагаа, туршлага судлах зардалд 4.7 сая нийт 21.2 сая төгрөгийг зарцуулсан байна.*

2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу баталгаажин, нэгдсэн хяналттайгаар хэрэгжиж байна уу?

Төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагаанд хяналтыг хуулийн хүрээнд хэрэгжүүлж буй хэдий ч дансны үлдэгдэл баталгаажуулаагүй, санхүүжилтийн эрх олгох журам зөрчсөн, баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн зэрэг зөрчлүүд гарч байна.

2.2.1. Төв төрийн сан нэгдсэн данс, бүртгэлийн дансны төлбөр тооцоо, гадаад валют, үлдэгдэл, баталгааг хугацаандаа холбогдох системд бүртгэх, Монгол банк дахь төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлтэй тулган баталгаажуулж, зөрүүг тухай бүр залруулах арга хэмжээг авч байна уу?

Аймаг, сумын төрийн сангийн нэгжүүд нь харилцагч 28 байгууллагын дансны үлдэгдлийн баталгааг бүрэн баталгаажуулж баримтжуулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1⁷ дэх заалтын дагуу санхүүгийн хөрөнгийг Монгол банканд байрших төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан удирдах бөгөөд хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1⁸ дэх заалтын дагуу төв төрийн сангийн нэгдсэн дансыг удирдах чиг үүрэг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хамаарч байна. Түүнчлэн хуульд аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн чиг үүрэгт Монгол банктэй хамааралтай чиг үүрэг тусгагдаагүй байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 1516 данс бүртгэлтэйгээс улсын төсвийн 495, орон нутгийн төсвийн 1021, үүнээс 1208 данс идэвхтэй, 308 данс идэвхгүй төлөвтэй байна.

Хүснэгт №9. Баянхонгор аймгийн Төрийн сангийн данс

№	Төрийн сангийн нэгж	Улсын төсвийн данс		Орон нутгийн төсвийн данс		Нийт данс	
		Идэвхтэй	Идэвхгүй	Идэвхтэй	Идэвхгүй	Идэвхтэй	Идэвхгүй
1	Аймаг	111	22	74	17	185	39
2	Баацагаан	5	10	42	3	47	13
3	Баянбулаг	6	9	41	3	47	12
4	Баянговь	8	9	41	3	49	12
5	Баянлиг	8	11	41	5	49	16
6	Баян-Овоо	5	10	43	2	48	12
7	Баян-Өндөр	5	10	41	3	46	13
8	Баянхонгор	39	26	72	7	111	33
9	Баянцагаан	6	9	42	3	48	12
10	Богд	6	9	42	3	48	12
11	Бөмбөгөр	6	9	43	2	49	11
12	Бууцагаан	8	11	45	2	53	13
13	Галуут	8	9	43	2	51	11
14	Гурванбулаг	6	9	41	3	47	12
15	Жаргалант	6	9	41	3	47	12
16	Жинст	5	10	42	3	47	13
17	Заг	5	10	41	3	46	13
18	Өлзийт	6	9	43	3	49	12

⁷ - Санхүүгийн хөрөнгийг Монголбанкинд байрших Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан удирдана.

⁸ - Төрийн сангийн нэгдсэн дансыг удирдах.

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл

19	Хүрээмарал	6	9	41	4	47	13
20	Шинэжинст	5	10	42	2	47	12
21	Эрдэнэцогт	6	9	41	3	47	12
		266	229	942	79	1208	308

Эх сурвалж: СТСХ-ийн дансны жагсаалт

Аймгийн СТСХ нь 2023-2025 онд 26 дансыг шинээр нээх хүсэлтийг Сангийн яамны Төрийн сангийн газарт албан бичгээр хүргүүлж нээсэн байна. Үүнд:

- Төрийн архивын хэлтэс-1
- Худалдан авах ажиллагааны газар-1
- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сан-1
- Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ, барьцаа хөрөнгө-19
- Хот тохижилт үйлчилгээний газар Баянхонгор сумруу шилжсэн-2
- Аймгийн Татварын газрын дэргэдэх “Ахмадын зөвлөл” ГҮТББ-1
- Аймгийн ХХҮГ-ын ахмадын сан-1

Мөн Баянлиг сумын Галуун дэл багийн бага суургууль татан буугдсан, аймгийн ГХБХБГ-ын 2 данс өөрчлөгдсөн тул 3 данс хаах хүсэлтийг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлж дансыг идэвхгүй болгосон байна.

Аудитын хугацаанд аймгийн СТСХ, Баянхонгор сумын идэвхтхитэй 296 дансны 2024-2025 оны эхний хагас жил, жилийн эцсийн үлдэгдлийн баталгааг тулган шалгахад дараах байдалтай байна.

Хүснэгт №10. Дансны үлдэгдлийн баталгаа

Үзүүлэлт	2024 он		2025 он		Нийт
	Эхний хагас жил	Жилийн эцэс	Эхний хагас жил	Жилийн эцэс	
Баянхонгор аймаг					
Батлгаажуулах данс	185	185	185	185	740
Баталгаажуулсан	95	105	100	100	400
Үүнээс: Зөрүүгүй	85	92	92	91	360
Зөрүүтэй	10	13	8	9	40
Баталгаажуулаагүй	90	80	85	85	340
Баянхонгор сум					
Батлгаажуулах данс	111	111	111	111	444
Баталгаажуулсан	57	50	57	61	225
Үүнээс: Зөрүүгүй	48	47	50	57	202
Зөрүүтэй	9	3	7	4	23
Баталгаажуулаагүй	54	61	54	50	219
Нийт					
Батлгаажуулах данс	296	296	296	296	1184
Баталгаажуулсан	152	155	157	161	625
Үүнээс: Зөрүүгүй	133	139	142	148	562
Зөрүүтэй	19	16	15	13	63
Баталгаажуулаагүй	144	141	139	135	559

Эх сурвалж: Аудитын тулгалт

Тулгалтаар давхардсан тоогоор 2024-2025 онд нийт баталгаажуулах 1184 дансны 47.2 хувь 559 дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй, 52.8 хувь буюу 625 дансыг баталгаажуулан баримтыг архивын нэгж болгон үдсэн ба 10.1 хувь буюу 63 дансны үлдэгдлийг зөрүүтэй баталгаажуулсан байна.

Баталгаажуулаагүй дансны ихэнхи хувийг төсөвт байгууллагуудын орон нутгийн орлогын болон ахмадын сангийн данс эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн СТСХ болон Баянхонгор сумын идэвхтэй 296 дансны 2024-2025 оны эхний хагас жил, жилийн эцсийн дансны үлдэгдлийн баталгааг тулган шалгахад 47.2 хувийг баталгаажуулаагүй, 10.1 хувийг зөрүүтэй баталгаажуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.24-т "Энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан албан тушаалтан бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг мөн журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үйлдэн хагас жил тутам харьяа төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд дансны үлдэгдлийн баталгааг үнэн зөв, бүрэн баталгаажуулж архивын нэгж үүсгэж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

2.2.2. Төрийн сан, төсвийн байгууллага бүртгэлийн дансны төлбөр тооцоо, төлбөрийн хүсэлт, зарлагын гүйлгээг хийхдээ эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэг, үндэслэх баримт бичиг, мэдээллийг үнэн зөв бүрдүүлж, зориулалт, ангиллын дагуу гүйцэтгэсэн үү?

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтын эрхийг олгохдоо журамд заасны дагуу баримтыг бүрдүүлээгүй байхад нээж олгосон байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд улсын төсвийн 145 байгууллага, орон нутгийн төсвийн 50 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуй нэгж 7 өрхийн эрүүл мэндийн төв 4, тусгай сан 41, нийт 247 байгууллагад 157 нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж байна.

Төсвийн байгууллагууд нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтийг Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.12.2 -т заасны дагуу 2023 онд 4,192.5 сая төгрөгийн 162 хүсэлт, 2024 онд 9,960.9 сая төгрөгийн 434 хүсэлт, 2025 онд 13,524.7 сая төгрөгийн 251 хүсэлтийг төрийн санд ирүүлснийг шийдвэрлэсэн байна. Үүнээс 2023-2025 онд баримтын бүрдэл бүрэн 25,008.3 сая төгрөгийн 708 хүсэлт, баримтын бүрдэл дутуу 2,669.8 сая төгрөгийн 139 хүсэлт байна.

Хүснэгт 11. Нэмэлт төсвийн зарцуулалтын гүйлгээний нэгтгэл (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2023 он		2024 он		2025 он	
	Хүсэлтийн тоо	Мөнгөн дүн	Хүсэлтийн тоо	Мөнгөн дүн	Хүсэлтийн тоо	Мөнгөн дүн
Нийт хүсэлт	162	4,192.5	434	9,960.9	251	13,524.7
Баримт бүрдэл бүрэн	84	2,993.5	401	8,698.3	223	13,316.4
Баримт бүрдэл дутуу	78	1,198.9	33	1,262.5	28	208.3

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтын эрх нээсэн баримт

Аудитын илрүүлэлт:

Төсвийн байгууллагуудын 2023-2025 оны Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтийн 2,669.8 сая төгрөгийн 139 хүсэлт баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.12.2⁹-т заасныг дагаж мөрдөөгүй байна.

⁹ 2.12.2.Төсвийн байгууллага нь нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтийг дараах баримт бичгийн хамт цахимаар, эсхүл албан бичгээр харьяалагдах төрийн санд хүргүүлнэ:

Иймд “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.12.2¹⁰-т заасны дагуу баримтын бүрдэл бүрэн гүйлгээнд эрх олгож байхыг аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст зөвлөмж хүргүүлэв.

СТА-аар 2023-2025 онд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4¹¹, 13.6¹², 13.7¹³ дахь заалтыг тус тус зөрчсөн анхан шатны баримтын бүрдэл дутуу 245.7 сая төгрөгийн 31 зөрчил илэрч 10.9 сая төгрөгийн 12 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 116.9 сая төгрөгийн 16 албан шаардлага, алдааг давтан гаргахгүй байх 117.9 сая төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг тооцож ажилласан.

Хүснэгт 12. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчлийн нэгтгэл (сая төгрөгөөр)

Гаргасан шийдэл	2023 он		2024 он		2025 он	
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
Албан шаардлага	6	60.5	8	48.0	2	8.4
Зөвлөмж	1	3.2			2	114.7
Төлбөрийн акт	7	6.8	2	1.4	3	2.7
Нийт	14	70.4	10	49.4	7	125.9

Эх сурвалж: Зөрчлийн нэгтгэл

Аудитын илрүүлэлт:

Аудитын явцад Улс, орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн дансны 100 сая төгрөгөөс дээш 41,463.4 сая төгрөгийн 244 гүйлгээг түүвэрлэн анхан шатны баримтын бүрдлийг үзэхэд сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын гүйлгээнд 6,708.1 сая төгрөгийн 47 гүйлгээ гүйцэтгэлийн баримт, тайлангүй зөвхөн гэрээг хавсарган гүйлгээг хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7¹⁴, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан” Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.10¹⁵-т заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд гүйлгээг ижил түвшинд хянах, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг хийхгүй байх, гүйлгээнд тавих хяналтыг сайжруулж зөрчлийн таслан зогсоох албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст өгөв.

2.2.3. Төв төрийн сан, бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, буцаалтыг журмын дагуу дансанд байршуулж, холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг залруулан буцааж байна уу?

Тодорхойгүй нэр данс зөрүүтэй орлогын буцаалтыг журмын дагуу холбогдох баримтыг үндэслэн залруулсан байна.

Нэр данс зөрүүтэй орлого 2023 онд 1,525.8 сая төгрөгийн 708 гүйлгээ, 2024 онд 3,294.1 сая төгрөгийн 1,022 гүйлгээ, 2025 онд 3,304.7 сая төгрөгийн 927 гүйлгээ гарсан байна.

¹⁰ Төсвийн байгууллага нь нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтийг дараах баримт бичгийн хамт цахимаар, эсхүл албан бичгээр хүргүүлнэ.

¹¹ - Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

¹² - Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

¹³ - Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

¹⁴ - Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

¹⁵ - Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана;

Хүснэгт 13. Нэр данс зөрүүтэй орлогын нэгтгэл (сая төгрөгөөр)

№	Он	Тоо	Дүн
1	2023 он	708	1,525.8
2	2024 он	1,022	3,294.1
3	2025 он	927	3,304.7
Нийт дүн		2,657	8,124.6

Эх сурвалж: Дансны хуулга

Сангийн яамнаас хийсэн Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн 2025 оны дотоод хяналтын тайланд Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.21¹⁶-т гэж заасныг баримтлан төсөвт байгууллагуудад зөвлөмж хүргүүлэн ажиллах гэсэн зөвлөмжийг өгсөн байна.

2.2.4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо болон холбогдох тохируулгын тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, тайлагнаж байна уу?

Төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь тайлагнаж байна.

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4¹⁷, 54 дүгээр зүйлийн 54.5¹⁸ дахь заалт, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу төсөвт байгууллагууд нь дараах тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж тайлагнаж байна. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 02-ны өдрийн дотор гаргаж төрийн сангийн мэргэжилтнээр хянуулж, архивын нэгж үүсгэж хэвшсэн ба цахим системд шилжсэнээр ач холбогдол багассан байна.
- ТШЗ, Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, ТТЗ, ТЕЗ нь Төсвийн тухай хуульд заасан цаглабрын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж дээд шатны төсөв захирагчид, аудит хийсэн тайланг хуулийн хугацаанд харьяалах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ТЕЗ нь 2023-2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн яамны Э-Тайлан цахим системээр, 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг “Finperform” цахим системээр нэгтгэн тайлагнасан байна.

Төрийн аудитын байгууллагаас ТТЗ-ийн 2023-2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтыг хэрэгжүүлээгүй зөрчилд 2023 онд Баянхонгор аймгийн ТЕЗ болон 4 сумын ТТЗ-д зөвлөмж, 2024 онд 12 сумын ТТЗ-д албан шаардлага хүргүүлсэн байна.

ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтэд төрийн өмч ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бодлого удирдлагаар хангах арга хэмжээний шалгуур үзүүлэлт тодорхой бус байдлаас шалтгаалж, орон нутгийн өмчийн хадгалалт хамгаалалт, ашиглалт хангалтгүй байгаа тул шалгуур

¹⁶ - Төсвийн байгууллагын орлогын хуулгыг өдөр тутам хянаж, тодорхой бус орлогын талаар нягталж, орлого бууруулах гүйлгээг гаргахдаа холбогдох нотлох баримт болон орлогын дэлгэрэнгүй хуулгыг төлбөрийн хүсэлтийн хамт гаргаж, ажлын 3 өдрийн дотор төрийн санд мэдэгдэн залруулах хүсэлт гаргана

¹⁷ - Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.

¹⁸ - Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

үзүүлэлтийг хэмжигдэхүйцээр тодорхой болгох зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж ажилласан байна.

Аймаг, сумын ИТХ нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9¹⁹, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3²⁰ дахь заалтын дагуу тухай жилийн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлан бүрэн эрхтэй бөгөөд аймгийн ИТХ нь аймгийн ТЭЗ-ийн 2023 оны төсвийг гүйцэтгэлийг 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 3/17 тоот тогтоол, 2024 оны төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 8/44 тоот тогтоолоор тус тус баталсан ба 2025 оны төсвийн гүйцэтгэл батлагдаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн 11 сумын Санхүүгийн алба нь 2023-2024 оны төсвийн гүйцэтгэлийг сумын ИТХ-д танилцуулан тогтоолоор баталгаажуулсан, 9 сумын Санхүүгийн алба нь төсвийн гүйцэтгэлийг сумын ИТХ-д танилцуулсан боловч тогтоолоор баталгаажуулаагүй байна.

Энэ нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9-д “Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах”, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3-т “Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, дүнг сумын ИТХ-д танилцуулан хэлэлцүүлж, тогтоолоор баталгаажуулах зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

2.3. Төрийн сангийн үйл ажиллагаа, хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч жил бүрийн илэрч буй зөрчлийн тоо буурахгүй байгаа нь хяналтын үр нөлөөг сулруулж байна.

2.3.1. Төрийн сангийн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус дотоод хяналтыг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тогтмол хэрэгжүүлж, тайланг гаргаж, удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан уу?

Төрийн сангийн төлөвлөгөөт дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 8 дахь хэсгийн 8.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Төрийн сангийн нэгжүүдэд дотоод хяналт хийх төлөвлөгөөг 2023-2025 онд аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан хэрэгжилтийг Сангийн яамны Төрийн сангийн газарт жил бүр хүргүүлсэн байна.

Аймгийн СТСХ нь 2023-2025 онд нийт 48 хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 36 дотоод хяналтыг цахимаар, 12 нэгжид очиж дотоод хяналтыг хийж 21 зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

¹⁹ - Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах

²⁰ - Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах

Хүснэгт 14. Дотоод хяналтын төлөвлөгөө, гүйцэтгэл

Он	Дотоод хяналт			Зөвлөмжийн тоо
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл		
		Газар дээрх хяналт	Цахим	
2023	10	4	6	-
2024	9	4	5	9
2025	29	4	25	12
Нийт	48	12	36	21

Эх сурвалж: СТСХ-ийн 2023-2025 оны дотоод хяналтын төлөвлөгөө, тайлан

Төрийн сангийн цахим системд шилжсэнээр дотоод хяналтыг цахимаар хэрэгжүүлэх боломжтой болсон бөгөөд энэ нь шатахуун, томилолтын зардлыг хэмнэх давуу талыг бий болгосон байна.

Аймгийн СТСХ нь 2023-2025 онд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгээгүй, өдөр тутмын хяналтыг тухай бүр хэрэгжүүлж ажилласан байна.

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн цахим шилжилтийн бодлого, зорилтын хүрээнд улс орон даяар төрийн сангийн төлбөр тооцооны систем цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотойгоор аймгийн СТСХ нь 2023 онд "Шилдэг цахим санхүүгийн алба" уралдааныг зохион байгуулж, үр дүнг тооцсон нь 21 аймгаас түрүүлж цахимд шилжсэн аймаг болоход гол нөлөөг үзүүлсэн байна.

Аймгийн СТСХ нь 2025 онд 20 сумын санхүүгийн алба, төсөвт байгууллагуудын нягтлан бодогчдыг хамруулан "UPDATE WORK-2025" уралдааныг зарласан нь хамт олны эерэг хандлагыг төлөвшүүлэх, бүтээлч санаачилгыг дэмжих, ажил мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд чухал түлхэц болсон байна. Мөн "Татварын бааз суурийг нэмэгдүүлэх, мэдээллийн зөрүүг арилгах" аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж, татварын нэр төрөл бүрээр мэдээллийн баазын зөрүүг арилгаж, татварын орлогын биелэлтэд ахиц гарсан байна.

Сангийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 56 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөө, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар 14-ний өдрийн А/101 тоот тушаалаар баталсан удирдамжийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн газар Баянхонгор аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн 2024-2025 оны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод хяналтаар 16 асуудлын хүрээнд хяналт хийж тус хэлтэст 6 зөвлөмж хүргүүлж, аймгийн СТСХ нь Сангийн яаманд 3 санал өгсөн байна.

Аймгийн СТСХ-ийн үйл ажиллагаанд 23 эрсдэлийн хүрээнд үнэлгээ хийхэд 18 эрсдэл "Бага", 4 эрсдэл "Дунд", 1 эрсдэл "Их" ач холбогдлын зэрэгтэй үнэлэгдсэн ба дараах эрсдэлийг үүсэх магадлалтай гэж үзсэн байна. Үүнд:

- *Харьяа төсөвт байгууллага нь цахим нэхэмжлэх үүсээгүй хийгдсэн гүйлгээг хянан баталгаажуулах.*
- *Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль, журмыг хэрэгжүүлэхэд хүндрэл тодорхойгүй асуудал гарах.*
- *Нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг олгоходоо иж бүрэн дутуу баримт бичгээр эрх нээх*

- Зориулалтын бус эх үүсвэрийн эдийн засгийн ангиллаас хийгдсэн гүйлгээг хянан баталгаажуулах
- Журам зөрчсөн орлого бууруулах гүйлгээг хянан баталгаажуулах.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь зөвлөмжийн дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн эрх нээх хүсэлтийг холбогдох журмын хүрээнд баримтын бүрдийг хянан ажилласан.
- Татварын орлогын биелэлтийн мэдээг аймгийн Татварын газрын холбогдох мэргэжилтэнтэй сар бүр тооцоо нийлж, орлогын биелэлтийг нэмэгдүүлэхийн тулд аймгийн Засаг даргын албан даалгавар болон захирамжаар тодорхой хэмжээний арга хэмжээ зохион байгуулсан.
- Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, сарын өглөг, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу хянан хүлээн авч байна.
- Сангийн яамтай зөвшилцөлгүй гүйлгээ хийсэн нягтлан бодогчдын зөвшилцлийн бичгийг авч зөрчлийг арилгасан байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 7/1375 дугаар албан бичгээр дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн байна.

2.3.2. Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг зааврын дагуу үнэлсэн мөн өдөр тутмын дотоод хяналтыг бүх шатны төрийн сангийн үйл ажиллагаанд батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу тогтмол хэрэгжүүлж, тайлагнан удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан уу?

Төрийн сангийн үйл ажиллагааны эрсдэлийг журмын дагуу үнэлж, дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч боловсон хүчин, тайлан мэдээ, баримтын бүрдүүлэлттэй холбоотой эрсдэл нийтлэг байна.

Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 5 дахь хэсгийн 5.3-т заасны дагуу аймаг, сумдын Төрийн сангийн үйл ажиллагааны эрсдэлийг үнэлж 2023 оны эрсдэлийн үнэлгээг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргын 2024.01.12-ны өдрийн 7/29 тоот албан бичгээр Сангийн яамны Төрийн сангийн газарт тус тус хүргүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Төрийн сангийн хэлтсийн үйл ажиллагааны 2023 оны эрсдэлийг журмын дагуу 19 үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд 1 сумын төрийн сан 41 буюу түүнээс дээш оноотой, 17 сумын төрийн сан 21-40 оноотой, 3 сумын төрийн сан 20 буюу түүнээс бага оноотой гэж үнэлсэн байна.

Дээрх үнэлгээгээр 41 буюу түүнээс үнэлгээтэй Богд сумын Төрийн сан 46 оноотой өндөр эрсдэлтэй, Галуут сумын төрийн сан 19 оноотой, Баянхонгор аймгийн төрийн сан 14 оноотой, Баянлиг сумын Төрийн санг 20 оноотой эрсдэл бага гэж үнэлсэн байна.

Төрийн сангийн нэгжийн эрсдэлийн үнэлгээний хуудсанд дараах асуултууд өндөр үнэлэгдсэн байна.

- Удирдах албан тушаалтан төрийн сангий үйл ажиллагааны хууль журмуудыг зөрчсөн шийдвэр гаргаж байсан уу

- Удирдах албан тушаалтан албан үүргийнхээ дагуу шийдвэр гаргахад мэргэжлийн мэдлэг чадвар хүрэхгүй байх тохиолдол гардаг уу
- Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хуульд заасан хугацаанд ирүүлдэггүй тохиолдол гардаг уу
- Бүртгэл дутуу баримтаар “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7,8 дахь хэсгүүдэд заасныг зөрчиж гүйлгээ хийдэг үү
- Өдрийн гүйлгээний баримтыг нягтлан бодох бүртгэлийн журналтай гүйлгээ өндөрлөсний дагуу тогтмол тулгадаггүй тохиолдол гардаг уу

Мөн аймаг, сумдын Төрийн сангийн 2025 оны үйл ажиллагааг Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заасны дагуу үнэлж 2024 оны эрсдэлийн үнэлгээг 2025.01.29-ний өдрийн 1а/71 тоот, 2025 оны эрсдэлийн үнэлгээг 2026.01.27-ны өдрийн 1а/67 тоот албан бичгээр Сангийн яамны Төрийн сангийн газарт тус тус хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 2 дугаар хавсралтын дагуу 22 асуултаар эрсдлийг үнэлсэн бөгөөд 2024 онд Боловсон хүчин дутмаг байх асуудалд Баян-Овоо, Эрдэнэцогт, Жинст, Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, боловсон хүчний мэдлэг чадвар дутуу асуудалд Баян-Овоо, Бөмбөгөр, Шинэжинст сумд тус тус өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байна.

Аймаг, сумдын төрийн сангийн үйл ажиллагааны эрсдлийн үнэлгээг хийж эрсдэлтэй асуудлуудыг дотоод хяналтын төлөвлөгөөнд тусгаж бууруулах, цаашид гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажилласан байна.

Төрийн сангийн мэргэжилтнүүд өдөр тутмын хяналтыг тухай бүр хэрэгжүүлж эдийн засгийн ангилал буруу, анхан шатны баримтын бүрдэл дутуу, захирамж тушаал байхгүй гэх мэт шалтгаанаар 2023 онд 11,794.9 сая төгрөгийн 5,099 гүйлгээ, 2024 онд 21,951.8 сая төгрөгийн 4,823 гүйлгээ, 2025 онд 24,466.8 сая төгрөгийн 4,559 гүйлгээг буцаасан байна.

Хүснэгт 15. Буцаасан гүйлгээний нэгтгэл(сая төгрөгөөр)

Он	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн
2023	5,099	11,794.9
2024	4,823	21,951.8
2025	4,559	24,466.8
Нийт дүн	14,481	58,213.5

Эх сурвалж: Дансны хуулга

2.3.3. Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Санхүү, төрийн сангийн хэлтсийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар хэрэгжүүлж байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын СТХС-ийн үйл ажиллагаанд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар жил бүрийн Санхүүгийн тайлангийн аудит болон гүйцэтгэл, нийцлийн аудитаар хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2023-2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 11,200.7 сая төгрөгийн 39 зөрчил илэрсэнд 148.0 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 8,378.9 сая төгрөгийн 18 зөвлөмж, 2,673.8 сая төгрөгийн 18 албан шаардлага өгсөн байна.

Гүйцэтгэл, нийцлийн аудитаар: 2025 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д хийсэн аудитаар 1 зөвлөмж, “Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлсэн орлого, орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт түүний үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар 1 албан шаардлага, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д хийсэн аудитаар 1 зөвлөмж, “Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар 2 зөвлөмж, 2026 онд гүйцэтгэсэн “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар 1 зөвлөмжийг тус тус аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн ба хэрэгжилтийг бүрэн тооцож ажилласан.

Хүснэгт 16. Санхүү, төрийн сангийн хэлтэст өгсөн зөрчлийн нэгтгэл (сая төгрөгөөр)

Аудитын төрөл	Гаргасан шийдэл	2023 он		2024 он		2025 он	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
Санхүүгийн тайлангийн аудит	Албан шаардлага	6	1,724.8	6	901.5	6	47.5
	Зөвлөмж	11	598.5	3	5,783.2	4	1,997.2
	Төлбөрийн акт	2	4.6	1	143.4	-	-
Гүйцэтгэлийн аудит	Албан шаардлага	-	-	1	-	-	-
	Зөвлөмж	1	-	1	-	3	-
Нийт		20	2,327.9	12	6,828.1	13	2,044.7

Эх сурвалж: Бүртгэлийн мэдээ 2023-2025 он

Төрийн аудитын байгууллага нь Санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд шилэн дансны цахим хянах эрх олгоогүйгээс шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад хугацаа их шаардаж, ажлын ачааллыг нэмэгдүүлж байна. Иймд Сангийн яаманд шилэн дансны хяналтын эрх олгуулах саналыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газарт уламжлав.

Аудитаар нийт 9,483.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 6,708.1 сая төгрөгийн 1 зөрчилд зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 2,775.4 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргуулахгүй байх, таслан зогсоох 4 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

-оОо-

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Төрийн сангийн төлбөр тооцооны систем цахимд шилжсэнтэй холбогдуулан холбогдох журмуудад өөрчлөлт оруулаагүй байна.
2. Орон нутагт ажиллах боловсон хүчний дутагдалтайгаас төрийн сангийн мэргэжилтнүүд санхүү албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа нь хяналтын тогтолцоог алдагдуулах эрсдэлтэй боловч цахим шилжилттэй холбоотойгоор орон нутгийн төрийн сангийн бүтцийг шинэчлэх нөхцөл үүссэн байна.
3. Төсвийн болон хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалтын эрхийг батлагдсан хуваарийн дагуу хугацаанд нь олгоогүйгээс өр төлбөр нэмэгдэж, төсөл, арга хэмжээ дутуу болон он дамжин хэрэгжих эрсдэл үүссэн байна.
4. Төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагаанд хяналтыг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн хэдий ч ижил түвшинд хэрэгжээгүй, дансны үлдэгдэл баталгаажуулаагүй, санхүүжилтийн эрх олгох журам зөрчсөн, баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн зэрэг зөрчлүүд гарч байна.
5. Төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа боловч жил бүрийн хяналт шалгалтаар илэрч буй зөрчлийн тоо буурахгүй байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулж байна.
6. Төрийн сангийн төлбөр тооцооны систем цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотойгоор аймгийн СТСХ нь 2023 онд "Шилдэг цахим санхүүгийн алба" уралдааныг зохион байгуулж, үр дүнг тооцсоноор 21 аймгаас түрүүлж цахимд шилжсэн аймаг болсон байна.
7. Баянхонгор аймгийн 11 сумын Санхүүгийн алба нь 2023-2024 оны төсвийн гүйцэтгэлийг сумын ИТХ-д танилцуулан тогтоолоор баталгаажуулсан, 9 сумын Санхүүгийн алба нь төсвийн гүйцэтгэлийг сумын ИТХ-д танилцуулсан боловч тогтоолоор баталгаажуулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ

1. Сумдын төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3-т заасны дагуу сумын ИТХ-д танилцуулан хэлэлцүүлж, тогтоолоор баталгаажуулж байх.

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА ТАНАА:

2. Санхүүжилтийн эрхийг олгохдоо орлогын гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн төлөвлөлттэй нь уялдуулж, төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулж, батлуулж байх.

3. Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох заалтыг мөрдөж, дансны үлдэгдлийн баталгааг хагас жил тутам бүрэн, үнэн зөв тулган баталгаажуулах
4. Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгохдоо “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.12.2 -т заасны дагуу баримтын бүрдэл бүрэн гүйлгээнд эрх олгож байх

Зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн дотор, хэрэгжилтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

Аудитын нэгдсэн тайланд зөвлөмжөөр оруулах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу жижиг мөнгөн сангийн эрх нээж журмын хэрэгжилтийг хангуулах
2. Төрийн сангийн цахим шилжилттэй холбоотойгоор сумын санхүүгийн албаны бүтцийг шинэчлэх
3. Шат шатны төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын жишиг тодорхойлолтыг батлах
4. Хөндлөнгийн хяналт хэрэгжүүлдэг Төрийн аудитын байгууллагад Шилэн дансны цахим (портал цахим хуудас) системийн болон шаардлагатай бусад хяналтын эрх олгох

-oOo-